

## ТОДРУУЛГА

Нийслэлийн Амгалан амаржих газрын тендерийн хороонд 2024.09.23-ны өдөр Агниста фарм ХХК-аас багц 13-тай холбоотой албан бичиг, шинжилгээний дүгнэлтийг хүргүүлсэн. Уг албан бичигт дотоодод үйлдвэрлэгддэг нэг удаагийн тариур /1мл, 3мл, 5мл, 10мл, 20мл/ бүтээгдэхүүнүүдийг импортын бүтээгдэхүүнтэй хамт багцалсан тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 10 дугаар зүйлийн 10.4 заалтуудыг үндэслэн бүтээгдэхүүнүүдийг тусад нь багцалж өгөхийг хүссэн байсан.

Тендерийн үнэлгээний хороо Төрийн худалдан авах ажиллагааны газраас зөвлөгөө авч, үнэлгээний хорооны хурлыг хийн компаны хүсэлтийг үндэслэлтэй гэж үзсэн тул дараах шийдвэрийг гаргасан болно. Үүнд:

1. Багц 13-д байгаа нэг удаагийн тариуруудыг тусад нь нэг багц болгох. Тухайн багцыг 37-р багц болгож Нэг удаагийн тариурууд нэртэйгээр цахим систем болон баримт бичгүүдэд тусгах.
2. Багц 13-д үлдсэн хэрэгслүүд нь бүгд нэг удаагийн хэрэгслүүд тул Нэг удаагийн хэрэгслүүд 5 нэртэй болгон нэрийг өөрчлөх
3. Оролцож буй компаниудад чирэгдэл учруулахгүйгээр өөрчлөлтийг нэн даруй хийж гүйцэтгэх.

Тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолт, нийлүүлэлтийн хуваарьт эдгээр өөрчлөлтүүдийг хийсэн тул тендерт оролцож буй компаниуд өөрчлөлттэй танилцаж, тендертээ оролцоорой.

ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО